- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107, 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолоор "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ"-г шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187,071.3 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 131,972.3 | 213,728.4 | 81,756.1 |
| Бараа материал | 126,723.3 | 110,521.9 | (16,201.4) |
| Үндсэн хөрөнгө | 2,086,330.7 | 1,833,704.7 | (252,626.0) |
| **Нийт хөрөнгө** | **2,345,026.3** | **2,157,955.0** | **(187,071.3)** |
| Өр төлбөр | 125,322.4 | 202,368.9 | 77,046.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,219,703.9 | 1,955,586.1 | (264,117.8) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,345,026.3** | **2,157,955.0** | **(187,071.3)** |

Авлага дансны үлдэгдэл 213,728.4 мянган төгрөг болж 81,756.1 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны 202,368.9 мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 110,521.9 мянган төгрөг болж 16,201.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 371,420.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 387,621.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 3,113,802.5 мянган төгрөг болж 103,185.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 71,591.9 мянган

төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг худалдан авсан, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас 9 ширхэг нийт 24,291.0 мянган төгрөгийн, ТАЗ-өөс 1 ширхэг 5,250.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон сумдын соёлын төвүүдэд 16,194.0 мянган төгрөгийн 6 ширхэг зөөврийн компьютерыг балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эхэнд ХХОАТ-ын 671.9 мянган төгрөг болон хөрөнгө оруулалтын 124,650.5 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байсныг тайлант хугацаанд төлж барагдуулсан бөгөөд нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 202,368.9 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,955,586.1 мянган төгрөг болж 264,117.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ЗДТГ-ын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,396,804.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 880,898.6 мянган төгрөгөөр бууруулж, 3,515,905.5 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалингийн зардлыг 131,673.4 мянган төгрөгөөр,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11,971.4 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 132,073.2 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 33,844.4 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 6,728.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 270,928.7 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 82,387.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 68,025.4 мянган төгрөгөөр,
- Уналга, цугларалт, бэлтгэл сургуулийн зардлыг 30,040.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 30,701.1 мянган төгрөгөөр,
- Орон нутгийн нөөц хөрөнгийг 59,700.0 мянган төгрөгөөр,
- Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл сурталчилгааны зардлыг 2,826.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны эцэст батлагдсан төсвийг нэмэгдүүлж, 4,005,897.9 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийгдсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,960,897.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 45,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,960,897.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, үндсэн үйл ажиллагааны орлого 35,817.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,819,194.3 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь орон нутгийн нөөц хөрөнгийн зардал 138,749.1 мянган төгрөгөөр, мэдээлэл сурталчилгааны зардал 24,834.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,113,585.5 | 1,093,915.2 | 19,670.3 | 98.2 |
| 2 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 552,857.7 | 551,511.1 | 1,346.6 | 99.7 |
| 3 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 570,039.1 | 568,943.7 | 1,095.4 | 99.8 |
| 4 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 26,634.3 | 1,800.0 | 24,834.3 | 6.8 |
| 5 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 25,222.6 | 24,449.9 | 772.7 | 96.9 |
| 6 | Биеийн тамирын уралдаан, тэмцээн | 3,000.0 | 2,999.0 | 1.0 | 99.9 |
| 7 | Уналга, цугларалт бэлтгэл сургууль | 15,000.0 | 15,000.0 | 0.0 | 100.0 |
| 8 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 103,758.7 | 103,614.5 | 144.2 | 99.9 |
| 9 | Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх | 10,500.0 | 10,410.0 | 90.0 | 99.1 |
| 10 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 1,585,300.0 | 1,446,550.9 | 138,749.1 | 91.2 |
| | **Дүн** | **4,005,897.9** | **3,819,194.3** | **186,703.6** | **95.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130051415 тоот дансанд нийт 1,598,858.9 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрүүлж, 1,369,741.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, 229,117.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ. Үүнд:

- Татаас санхүүжилтийн авлагын 115,000.0 мянган төгрөг,

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын санхүүжилт 850,599.0 мянган төгрөг,
- Архивын гэрээт ажилчдын цалинд 21,110.9 мянган төгрөг,
- Төрийн албаны шалгалт зохион байгуулах зардалд 6,759.0 мянган төгрөг,
- ЗГХЭГ-аас олгосон шагналын 200,000.0 мянган төгрөг,
- ОНХС-аас улсын баяр наадмын зардалд 200,000.0 мянган төгрөг,
- НҮБ-аас аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хийлгэх ажлын санхүүжилтэд 120,000.0 мянган төгрөг,
- Гамшгаас урьдчилан сэргийлэх зардалд 44,973.9 мянган төгрөг,
- Төслийн сургалтад 40,416.0 мянган төгрөг зэрэг.

Нэмэлт төсвийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.*" гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Санхүүгийн тайлан болон төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,820,719.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **28,207.2**

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Аймгийн Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглосон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1.2 дахь заалтын хүрээнд Нийгмийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч Ц.Рэгзэдмааг ажлаас чөлөөлсөн,
- Бараа материалыг шаардлага гарсан хугацаанд хэрэгцээ шаардлагын дагуу татан төвлөрүүлж, зарцуулсан,
- Байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэглээнд хэмнэлт хийж цахилгаан, цэвэр бохир усны зардлыг хэмнэсэн,
- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хорны зардлыг төсвийн хэмжээнд зарцуулсан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ЗДТГ нь мэдээлбэл зохих 22 нэр төрлийн 186 мэдээллээс 77 мэдээллийг хугацаа хоцроож, дараах 5 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ (*Сар бүр*)-12 дугаар сарын,
- Ковид-19 цар тахалтай холбоотой мөнгөн хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ (*Сар бүр*)-12 дугаар сарын,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (*Сар бүр*) -12 дугаар сарын,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (*Сар бүр*)-9, 12 дугаар сарын мэдээг тус тус мэдээлээгүй.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн тул зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналтын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,226.0 мянган төгрөгийн албан шаардлага, 101,067.1 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 6,226.0 | 2 | 6,226.0 | 100.0 |
| Зөвлөмж | 4 | 101,067.1 | 3 | 65,856.5 | 75.0 |
| **Нийт дүн** | **6** | **107,293.1** | **5** | **107,293.1** | **83.3** |

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй албан байранд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хийсэн гэрээнд эзэмшүүлэн ашиглуулж буй өрөөнүүдийн тоо хэмжээ болон ашиглалтын зардлын төлбөрийн дүн, төлбөр төлөх данс зэргийг тодорхой тусгаагүйгээс Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны ашиглалтын зардлын нийт 11,054.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогод бус нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

Үүнээс шалтгаалан үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө бодит байдлаар биелсэн боловч 9,182.7 мянган төгрөгөөр тасарснаар тайлагнагдсан байна.

Иймд байгууллагуудтай хийгдэж буй ашиглалтын гэрээнд дээрх нөхцөлүүдийг бүрэн тусгаж, төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 35,619.8 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 26,454.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9,165.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Төсвийн төлөвлөгөөг бодит байдал, тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөдөггүйгээс зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас дотоод үйл ажиллагаанд зориулагдсан цай, кофе, ус, ундаа болон бусад бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд нийт **11,051.6** мянган төгрөгийг зориулалт бусаар гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "*Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална*", *5.1.2: "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"*, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр "Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын хавсралтад *"210703: Зочин төлөөлөгч хүлээн авах: Монгол Улсад гадаад улс орнуудаас албан ажлын айлчлалаар ирэх зочин төлөөлөгч, ... айлчлалтай холбоотойгоор гарах зочид буудал, хоол, унаа, бэлэг дурсгалын эд зүйлс бэлтгэх зардал энд хамаарна"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн үнэн зөв төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5.1.2. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр буюу монгол банкны байрыг түрээсэлсний 2021 оны 4 дүгээр улирлын түрээсийн төлбөр болох **2,794.7** мянган төгрөгийг тайлант оны төсвөөс шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*", 14.4.3-д "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан мэдээллийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлэх, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.1.3. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас аймгийн Цэргийн штабын албан хэрэгцээнд 1,899.0 мянган төгрөгийн суурин компьютер худалдан авч, төсөв хүрэлцээгүйн улмаас **599.9** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "*Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэлгүй, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах албан шаардлага хүргүүлэх.

5.1.4. Албан хаагчдын албан томилолтоор ажилласан хугацаанд унаа, хоолны хөнгөлөлт **438.0** мянган төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын хугацаанд унаа, хоолны хөнгөлөлт олгохгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.1.5. Тухайн байгууллагад ажилладаггүй 7 хүнд шинэ жилийн баярыг тохиолдуулан **490.0** мянган төгрөгийн тусламж олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.1.6. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй нийт **11,080.6** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д *"Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ..."* гэсэн заалтуудыг зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх *"Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"*, 4.2.1.10: *"Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Анхан шатны баримт материалтай холбоотой:**

*Илрүүлэлт:* Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтлөлгүйгээр буюу анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт **9,165.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн*

*зөв гаргах үндэслэл болно"*, 13.7 дэх *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

**Санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь *"Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна"*, 8.1.5 дахь *"санхүүгийн тайлангийн тодруулга"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг иж бүрэн хийж байх.

**Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 347 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т иргүүлж шийдвэрлүүлнэ*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаал-тны тоо | Тоо | Дүн |
| Төсвийн төлөвлөлтийг үнэн зөв хийгээгүйгээс батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 11,051.6 | | | 1 | 11,051.6 | | | | | | |
| Өмнөх оны тайлагнагдаагүй өр төлбөрийг тайлант оны төсвөөс барагдуулж, бүртгэсэн | 1 | 2,794.7 | | | 1 | 2,794.7 | | | | | | |
| Өр төлбөр үүсгэсэн | 1 | 599.9 | | | 1 | 599.9 | | | | | | |
| Унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож олгосон. | 1 | 438.0 | | | 1 | 438.0 | | | | | | |
| Төсвийг үр ашиггүй зарцуулсан | 1 | 490.0 | | | 1 | 490.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан | 1 | 11,080.6 | | | 1 | 11,080.6 | | | | | | |
| Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн | 1 | 9,165.0 | | | | | 1 | 9,165.0 | | | | |
| Санхүүгийн тайлан тодруулгыг иж бүрэн хийгээгүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| Үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **9** | **35,619.8** | | | **6** | **26,454.8** | **3** | **9,165.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөр-ийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроосон | 77 | | | | | | 77 | |
| Огт мэдээлээгүй | 5 | | | | | | 5 | |
| **Дүн** | **82** | | | | | | **82** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | **82** | | | | | | 82 | |
| **Нийт дүн** | **82** | | | | | | **82** | |